МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр Дугаар А/149 Зуунмод

Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг
дахин зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журамын 10.1, аймгийн Засаг даргын 2019 оны А/29 дүгээр захирамжийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2018 оны А/627 дугаар захирамжаар газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулсан 44 байршлаас газарөмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын 10.1.1 дэх заалтын дагуу дуудлага худалдааг дахин явуулах нөхцөл бүрдсэн Зуунмод сумын Номт 1-р багт 11 байршил тус бүр 400 $м^2$ газрыг эзэмшүүлэх дахин дуудлага худалдааг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны анхны үнэ, дэнчинг өмнөх дуудлага худалдааны тогтоосон үнийг мөрдөж ажилсугай.

3.Батлагдсан төлөвлөлтийн дагуу газар эзэмшүүлэх дахин дуудлага худалдааг танхимын хэлбэрээр явуулахыг Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /М.Отгонбат/ нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ж.БАТЖАРГАЛ

01 00 281